

# Манмин Мэдээ

№ 44 2014 оны 3 сарын 2

## Ариусал, Хайр, итгэл Найдвараар дүүрэн үзэсгэлэнт магтаал

Бүх Манмины итгэгч нарын зүрх сэтгэлийн өөрчлөлт ба итгэлийн өсөлт



Манмины магтаалын үг, аялгуу бүрт Бурханы амьсгал, Түүний хайрын хамт, итгэгчдийн үзэсгэлэнтэй сайхан сэтгэлийг агуулсан байдаг.

И Жэй Руг пастор нь магтаал нь өдрөөс өдөрт ертөнцийн шинж чанартай болсоор байгаа талаар жаахан сэтгэл дундуур байдаг байна. Тэрээр Бурханы хүслийн дагуу Түүний баярлан таалах, мөн Түүнд алдрыг өргөх дуу бүжгийн хамтлагийг босгож, Магтаал дуу бүжиг урлагийн зөвлөлийг байгуулсан юм.

Бурхан Израйльчуудад Түүний хуулийг мөн хайрыг нь мартаггүйн тулд дуу өгсөний (Дэд хууль 31:19, 22) адилаар манай сүмд ч мөн Магтаалын багийг босгон тэднээр дамжуулан дэлхийн бүх Манмин сүмийн итгэгчдийн магтан дуулдаг “Манмины Магтаал”-г өгсөн билээ.

Дэлхийн 10,000 гаруй сүм чуулганы итгэгчид Манмины Магтаал гэдэг энэ дууг нөхөрлөлийн цаг, магтан дуундаа, залбиралдаа, мөн өдөр тутмынхаа амьдралдаа ч баяр хөөртэйгээр дуулж байгаа билээ. Үүгээр дамжуулан хүмүүсийн сэтгэл зүрх улам бүр ариусаж, Бурханы хүссэн үзэсгэлэнтэй сайхан сэтгэлийг олж аваад зогсохгүй жинхэнэ чин сэтгэлийн гэмшил, Ариун Сүнсний хүч нөлөөг дүүрэн авсан билээ.

Манмины магтаал их түгээмэл болсон бөгөөд Орос, Хятад, Япон, Англи гэх мэт олон хэлээр өөрсдийн төрөлх хэл рүү орчуулан дуулж байна. Мөн зарим нэгэн дууг Испани, Таталог (Филиппин), Тамил (Энэтхэг) хэлээр

хүртэл орчуулсан байна.

Энэтхэгийн Мадурай Манмин ариун сүмийн Персиял Ражадурай пастор “Бид Манмины Магтаалыг Тамил хэл дээр орчуулан магтан дуулж байгаа. Манай сүмийн итгэгчид магтан дуу дуулж байхад маш их ивээл авч, сэтгэл өөрийн эрхгүй хөдөлж, уйлдаг гэж гэрчилцгээдэг” гэжээ.

Японы Ида Манмин сүмийн магтан дууны удирдагч Смика Кумагай эгч дүүс “Манмины магтаалын шүлгийг нь л уншихад бусад дуунуудтай адилгүй Аав Бурханы, Эзний, хоньчны сэтгэлийг гүн мэдрүүлдэг. Аялгуу нь үнэхээрийн гайхамшигтай сэтгэлийн гүн рүү хүртэл нэвтрэн орж чаддаг. Эдгээр магтаал дуунууд нь манай сүмийн итгэгчдийг нэгтгэж, яг л нэг хүн шиг Ариун Сүнсээр дүүрэн магтаалыг өргөж чаддаг.

Дмитри Петровский пастор Израйльд бүх салбар сүмүүддээ Мамины Магтаалыг тараасан байна. Бурханы Манминд өгсөн магтан дуунуудаас маш их ивээл авсан, хэдийгээр би хөгжмийн мэргэжилтэй хүн ч гэсэн төсөөлөхийн аргагүй тийм гайхамшигтай сайхан аялгууг үнэхээр биширч байгаа гэж тэрээр хэлсэн билээ. Үг нь үгээр илэрхийлж, санаанд багтахын аргагүй яруу тансаг, тааламжтай. Манмины магтаалыг Израйльд маш олон үйл ажиллагаанд, Нэгдсэн их цуглаануудад дуулсаар байгаа бөгөөд оролцогчдод гүн сэтгэгдэл төрүүлж, асар их ивээл ерөөлийг өгсөөр байгаа билээ.

Магтан дуунууд улам бүр нэмэгдсээр байгаа бөгөөд тэдгээрийг нэрлэвэл:

нэгдүгээрт ‘Хоньчны Сэтгэл’; хоёрдугаарт, ‘Золиос’; гуравдугаарт, ‘Тэнгэрийн Орон’; дөрөвдүгээрт, ‘Найдвар’; тавдугаарт, ‘Орон зай’ гэсэн таван цомог болсон. Японд эдгээр таван цомогоос 26 дууг сонгон хэвлүүлсэн байна.

GCN ([www.gcntv.org](http://www.gcntv.org)) (Жи Си Эн) телевиз үзэгчиддээ зориулан Магтан дууны удирдагч Хан Жү геон номлогчийн бэлтгэн явуулдаг “Магтаал

өргөө” гэсэн хөтөлбөрөөр дамжуулан Манмины магтаалыг хэрхэн сайн дуулах, дуу хоолойны өнгө гаргах арга, амьсгал хуваарилах чадвар гэх мэт олон зүйлийг зааж өгдөг. Мөн Манмины магтаалыг И Жин сүмд үйлчлэгч бэлтгэн хөтөлдөг “Анхилуун Үнэр” гэдэг хөтөлбөрөөр үзэгчиддэ дагаж хөгжимдөхийг болон хөгжмийн суурь мэдлэгийг, магтаалын сүнслэг утгыг заадаг.

### Зурагны тайлбар

#### Цахим номнууд Загалмайн утга учир, Тэнгэр Орон I, Хятад хэлээр [amazon.com](http://amazon.com) гэсэн хаягаар унших боломжтой

И Жей руг пасторын Загалмайн утга учир, Тэнгэр Орон I гэсэн номнууд болон 2013 оны 11 сарын 27 ноос хойш [www.amazon.com](http://www.amazon.com)-р Хятад хэлээр цахим хэлбэрээр эдгээр номыг унших бүрэн боломжтой боллоо. Одоогийн байдлаар Тэргүүн Пасторын 90 орчим ном Хятад, Испани, Франц, Португал, Япон, Финлянд, Герман, Англи, Итал гэсэн 9 хэлээр цахим хэлбэрээр гарч байна.

Мөн гадаад орны энэхүү номын үйлчлэл нь Хятад хүмүүсийн нүдийг ихээр тагаж байгаа бөгөөд Тайланд Грэйс Паблшин Хаус гэдэг алдартай хэвлэлийн газарт хэвлэсэн И Жей руг пасторын номнуудыг 53 номын дэлгүүрээр, Америк, Канад, Австраль, Малайз, Хонг Конг, Сингапурт 31 номын дэлгүүрт тавьсан байна. Манмин хэвлэлийн газарт хэвлэсэн 10 гаруй номыг Хятад болон Малайзад тараасан нь уншихад илүү хялбар дөхөм болсон байна.



# Хайр бүгдийг тэсвэрлэдэг

“Хайр бол тэвчээртэй, ... бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг” (1 Коринт 13:4-7).



И Жей руг Тэргүүн пастор

1 Коринт 13-р бүлэгт гардаг сүнслэг хайрын шинж чанаруудын дунд “бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг” гэсэн байдаг.

Түрүүчийн удаа би та бүхэнд ‘бүгдийг далдлах’ гэдэг нь хайрлахад хэцүү байсан ч бүхнийг далдан өнгөрөөхийг хэлнэ гэж тайлбарласан билээ. Бүгдэд итгэх гэдэг нь ямар ч хүн байсан түүнд итгэж найдахыг хэлдэг бол, бүгдэд найддаг гэдэг нь итгэж буй зүйл нь бодитоор биелтэл нь хэрэгжих хүртэл хүлээхийг хэлнэ.

Энэ мэт бид бүх зүйлсийг итгэлээрээ бүгдэд найдаж, бүгдийг далдалсаар бас бид бүгдийг тэсвэрлэж чаддаг. Тэгвэл сүнслэг хайрын шинж чанарын дунд “бүгдийг тэсвэрлэх” гэдэг үг нь ямар утгатай юм бол? Сүнслэг хайрыг яаж бүрэн эзэмших, вэ?

## 1. Бүгдийг тэсвэрлэх гэж юу гэсэн үг вэ?

Сүнслэг хайртай зөрчилдөж буй бүх зүйлийг тэсвэрлэхэд түүнд дагалдах үр дагавар учирдаг. Далайн том давалгаа өнгөрсний дараа жижиг давалгаа үргэлжилдэг шиг бүгдийг тэсвэрлэхэд ч дараа нь сорилт ирэх юм уу зүрх сэтгэлийн шархтай үлдэх үе ч байдаг.

Есүс Матай 5:39д “Харин Би та нарт хэлье, хар санаатай хүнийг бүү эсэргүүц. Харин хэн баруун хацрыг чинь алгавал, түүнд нөгөө хацраа бас тавьж өг” гэж айлдсанчлан хэн нэгэн таны баруун хацрыг алгавал та буцаагаад цохихгүй эвтэйхэн тэсээд өнгөрсөн ч өвдөж, зүрх сэтгэлдээ шарх авч, хожим муу үр дагавартай учирч болох юм.

Мэдээж хүмүүсийн зүрх сэтгэлийн шарх авах учир шалтгаан нь өөр өөр байдаг. Зарим хүн доромжлуулсандаа

шууд уурладаг бол зарим ингэж маргалдана гэдэг өөрт нь эвгүй учир дотроо л шархалдаг хүмүүс байдаг. Мөн зарим нь уур хилэнгээ барьж чадалгүй тэр чигээр нь ил гаргаж байгаа ах дүүгээ хараад үнэхээр харамссандаа сэтгэл өвдөх үе ч байдаг.

Мөн төдийгүй аливаа зүйлийг тэсвэрлэхэд дагалдах үр дагавар нь бодит нөхцөл байдлаар ч ирж болно. Жишээлбэл нэг хүн таны баруун хацрыг алгахад та Бурханы үгийн дагуу дуулгавартайгаар зүүн хацраа тавьж өгтөл төсөөлөхийн аргагүйгээр мөн л зүүн хацрыг тань алгавал гэж бодъё. Та Бурханы үгийн дагуу сүнслэг хайртай зөрчилдөж буй зүйлийг тэвчсэн болохоор тэр даруй энэ хэцүү байдал арилах ёстой байтал харин нөхцөл байдал бүр дордож буй мэт санагдана. Тэгвэл үүний учир юу юм бол? Энэ нь Хайрын Бурхан биднийг улам бүр төгс төгөлдөр болгон дасгалжуулж, илүү их ивээл ерөөлийг өгөхийг хүсэж байгаатай холбоотой юм.

Ингэж тэсэж тэсвэрлэснээр дамжуулан бид зохистой “үр жимс”-г мөн боловсруулдаг. Энэ мэт сорилтоор дамжуулан Бурханы жинхэнэ үр хүүхэд болох нь хүн төрөлхтөнийг дасгалжуулан, боловсруулах Бурханы зорилго юм. Сүнслэг хайрыг бүрэн бий болгохоос өмнө нь хорон мууг үйлдэж байгаа хүнийг харахдаа гаднаа тэвчиж байгаа мэт боловч дотроо мөн л дургүйцэн тавгүйтэж ‘Би түүнийг ойлгохгүй байна. Түүнийг хармааргүй байна’ гэж боддог. Харин дайсан сатан диавол үүнийг мэддэг учраас сорилт авах болдог юм.

Бидний зүрх сэтгэлд хорон муугийн хэлбэр байхгүй болтол бидэнд ийм их бага хэмжээний сорилтууд байх болно. Гэм нүглийн бүх хэлбэрийг хаяж, зүрх сэтгэл маань бүрэн ариуссан ч сорилтууд ирж болно. Энэ төрлийн сорилт нь бидэнд ивээл өгөх гэсэн ерөөлийн сорилт юм. Тиймээс гэм нүгэлгүй болсон гээд нэг түвшиндээ зогсонги байлгүй улам өсөж илүү төгс сайхан сэтгэлтэй болох хэрэгтэй юм.

Ийм ерөөл нь зөвхөн хувь хүнд зориулсан ерөөл бус Бурханы хаанчлалыг илүү хүчтэй болгохын тулд ийм төрлийн ивээл хэрэгтэй. Бурханы хувьд том хэмжээний зүйлийг хийхдээ тэр хэмжээний шударга байдал бас нийцэх ёстой. Агуу их итгэл ба хайрын үйлсийг үйлдснээрээ хариулт авах хэмжээний нэгэн болохыг баталж өгсөнөөр дайсан сатан диавол зарга хийх боломжгүй болдог. Ийм учир хүнд хэцүү байдлыг тэсвэрлүүлэх үе ч бас байдаг.

Энэ л үед зөвхөн хайр болон сайхан сэтгэлээр бүхнийг тэсэж тэвчвэл эцэстээ ялалт байгуулж Түүнд алдрыг өргөх боломжоор биднийг хангаж өгдөг юм.

## 2. Бүгдийг тэсвэрлэж, мөн итгэж, найдахын тулд

Бид Бурханд хайртай учраас үнэн дотор бүгдийг тэсвэрлэж, мөн итгэж, найдвал ямар ч шалгалт сорилтыг хангалттай тэсэж чадна. Тэгвэл яаж бүгдийг тэсвэрлэж, мөн итгэж, найдах вэ?

### 1) Сорилтонд байсан ч Бурханы хайранд баг итгэх хэрэгтэй

Бурхан бидэнд энэ газрын амьдралын эцсийн мөчид зохистой нэгэнээр мөн алдар магтаал, хүндлэлийг авах болзолыг хангахын тулд сорилтыг зөвшөөрсөн байдаг (1 Петр 1:7). Түүнчлэн Бурханы үгийн дагуу амьдарч, ертөнцтэй нэгдэхгүй байх үед заримдаа хэцүү, шудрага бус асуудалтай тулгарах үе байдаг. Тэр болгонд та “Би Бурханы онцгой хайрыг авч байна” гэж итгэх хэрэгтэй юм. Тэгвэл бүх зүйл талархлын сэдэв болох ба илүү сайн тэнгэрийн орон руу удирдахын төлөө зөвшөөрч өгсөн ерөөлийн сорилт нь хичнээн талархууштай зүйл вэ?

Гэтэл сорилтын хугацаа удаан үргэлжилвэл “Бурхан надад үнэхээр хайртай болов уу?” гэж бодож магадгүй. Тэгэх тусам Бурханы хайранд итгэж, тэвчих хэрэгтэй билээ. Бурхан Аав намайг үнэхээр их хайрладаг учраас илүү Тэнгэрийн орон руу замчилж байгаад итгэх хэрэгтэй. Ингэж Бурханы хайранд итгэж, эцсээ хүртэл тэсвэрлэвэл эцэст нь төгс хүн болж ивээгдэх юм (Иаков 1:4).

### 2) Сорилт бол хүсэл найдвараа биелүүлэх дөт зам гэдэгт итгэх хэрэгтэй

Ром 5:3-4 дээр “Түүгээр ч барахгүй, мөн зовлонтойдоо баярладаг. Учир нь зовлон зүдгүүр нь тэвчээрийг, тэвчээр нь туршлагатай байхыг, туршлагатай байх нь найдварыг төрүүлдэг.” гэсэн байдаг. Энд хэлсэнээр сорилт нь хүсэл найдвараа биелүүлэх дөт зам юм. Заримдаа өөрийгөө харахдаа “Би хэзээ өөрчлөгдөх бол доо?” гэж бодож байж магадгүй ч дасаад ирэхээрээ гэрэлтэх эрдэнэс шиг сорилтыг тэсвэрлэж, өөрчлөгдөж, үргэлжлүүлэн өөрийгөө дахин дахин өөрчилсөөр байвал эцэст нь Бурханыг дуурайсан Түүний жинхэнэ, төгс нэгэн болно.

Түүнчлэн сорилтыг давахын тулд бүх хүч чадлаараа хичээн зүтгэх хэрэгтэй. Мэдээж хялбар аргыг сонгодог нь хүний

төрөлхийн хүсэл боловч сорилтоос хөндийрвөл тэр хэмжээгээр давахад хүндрэх болно Жишээлбэл: таньд үргэлж бүх зүйлд тань асуудал тарьдаг хүн байлаа гэж бодъё. Та гадагшаа нэг их чөлөөтэй илэрхийлээд байхгүй ч тэр хүнтэйгээ уулзах болгондоо нэг л тавгүйтээд байдаг учраас зүгээр л уулзахгүй байхыг, зугтахыг хүсдэг байна. Энэ тохиолдолд та нөхцөл байдлыг анзаарахгүй байх гэж хичээх хэрэггүй харин идэвхитэйгээр хичээнгүйлэн давах хэрэгтэй. Түүнчлэн сорилт бүхэн амжилтанд хүрэх шат, хүсэл найдвараа биелүүлэх дөт зам байх болно.

### 3) Бид зөвхөн сайныг үйлдэх хэрэгтэй

Махан бие талаас үзвэл шалгалт, сорилтууд нь өөр хүмүүсээс эсвэл ямар нэгэн нөхцөл байдлаас ирж байгаа мэт санагддаг. Гэвч сүнслэг байдлаар бол бүх итгэлийн сорилт нь дайсан Сатан диаволоос ирдэг. Өөрөөр хэлбэл шалгалт сорилтууд нь сайн, муугийн хоорондох тулаан юм. Ийм учраас энэ тулаанд ялахын тулд бид сүнслэг ертөнцийн сайн нь муугаа ялан дийлдэг хуулийн дагуу тулалдах хэрэгтэй. Хэрвээ бид энэ аргаар сайныг үйлдвэл, энэ нь бид хохирол амсч, тухайн үед ялагдаж байгаа мэт харагдавч яг үнэндээ эсрэгээрээ байдаг юм. Ром 12:21д “Бузар муугаар бүү дийл, харин бузар мууг сайнаар дийлэгтүн” гэж бичигдсэнчлэн Бурхан бол тэр чигээрээ сайн сайхан учраас сайныг үйлдэхэд гарцаагүй ялна.

Таны эргэн тойронд муухай зан гаргадаг, түүнийг огт ойлгохгүй хэн нэгэн байдаг уу? Тэгвэл та яагаад түүнд уудам сэтгэлээр жаахан сайнаа хандаж болохгүй гэж? Хэрвээ та сэтгэлдээ жинхэнэ хайрыг бий болгож чадвал тэсэж тэвчиж чадахгүй хүн гэж байхгүй болно. Хэрэв та Матай 22:39д “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэж тушаасны дагуу үйлдэх юм бол та бусдыг өөрийн адил хайрлаж, ойлгож бас тэр хүмүүсийн бүх зүйлийг хүлээн зөвшөөрөх чадвартай болох болно.

Хайрт итгэгч нараа, хясаанд дотор элс, далайн ургамал гэх мэт ямар нэгэн гадны биет ороход хясаа түүнийг гоёмсог сувд болгож өөрчилдөг. Би та бүхнийг итгэлээрээ “сүнслэг хайр” гэж нэрлэгддэг үзэсгэлэнтэй сайхан сувд адил болно гэдэгт итгэж байна. Тэгээд үзэсгэлэнтэй тэнгэрийн орны Сувдан хаалгыг өнгөрөх үед Бурхан Аавдаа “миний төлөө бүгдийг тэвчиж, итгэж, найдаж өгсөн Тандаа маш их баярлалаа” гэж сэтгэл хөдлөн гэрчлэх та бүхэн болохыг Их Эзэний нэрээр хүсэн ерөөж байна.


## Монгол Манмин Сүм

### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637  
 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773  
[www.manmin.org](http://www.manmin.org)  
[www.gcntv.org](http://www.gcntv.org)

# “Бурхан Гэрэл бий болог” гэж айлдав

Эхлэл 1-р бүлэгт энэ дэлхийн болон тэнгэрийн орны Бурханы бүтээлийн тухай тайлбарласан байдаг. Эхлэл 1:3-4т “Тэгээд Бурхан Гэрэл бий болог! гэсэнд гэрэл бий болов. Бурханыг харахад тэр гэрэл нь сайхан байв. Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ” гэсэн байдаг.

Энэ гэрэл яг ямар гэрэл байсан юм бол? Тэр үед нар хараахан бий болоогүй байсан үе учраас нарны гэрэл л лав биш нь тодорхой. Тэгвэл энэ ямар гэрэл байсан бэ? Бурхан яагаад “Гэрэл бий бол” гэж тушаасан учир нь юу вэ?

**Эхний өдөр бүтээсэн гэрэл бол ‘бүтээлийн угийн гэрэл’ юм**

Иохан 1:1-д “Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан” гэж бичигдсэний дагуу Бурхан тэнгэр газрыг бүтээхээс өмнө үг ба гэрлээр оршин байсан юм (1 Иохан 1:5). Гэрлээр оршигч Бурханаас угийн дуу гарсан. Тэр Гэрэл болон дуунд агуу их хүч чадал байдаг бөгөөд Бурханы эрх мэдэл бол ‘Угийн Гэрлээр ч’, ‘Угийн Дуугаар ч’ байдаг юм.

Бурхан анхнаасаа л хүн төрөлхтөнийг боловсруулахаар төлөвлөсний дараа Бурхан Аав, Ариун Хүү, Ариун Сүнсний дүр төрхөөр орших болсон юм. Тэгээд угийн гэрэл ба дуугаар оршиж байсан орон зай, сансар огторгуйг Сүнсний орон зай, болон махан биеийн орон зай хэмээн хуваасан юм.

Гурвал Бурхан цаг нь болоход махан биеийн ертөнцөд энэ дэлхийг бүтээсэн юм. Бүтээлийн нэг дэх өдөр “гэрэл бий болог” гэж айлдахад угийн гэрэл энэ дэлхий болон түүнийг агуулж буй энэ махан биеийн ертөнц болох сансар огторгуйд дүүрэн тархсан юм. “Махан биеийн орон зай” гэдэг нь зургаан өдрийн турш бүтээгдсэн дэлхий ертөнц, нарны аймаг, сансар огторгуй зааж буй ерөнхий нэршил юм.

Ийм бүтээлийн хүч нөлөөг бий болгосон угийн гэрэл нь “Бүтээлийн угийн гэрэл” гэдэг. Гурвал Бурхан 6 өдрийн турш тэнгэр газрыг бүтээж эхлэхдээ хамгийн эхлээд “Бүтээлийн угийн гэрэл”-г гаргаж дэг журмын дагуу нэг нэгээр нь бүтээсэн билээ.

**Ингэхэд Бурхан яагаад эхний өдөр махан биеийн орон зайг угийн гэрлээрээ бүрхсэн юм бол?**

Нэгдүгээрт: Сүнслэг орон зайг өмсгөн махан биеийн орон зайг сүнслэг цаг хугацааны урсгалд бүтээхийн тулд юм.

Махан биеийн ертөнц нь бүтээлийн эхний өдрөөс эхлэн махан биеийн урсгалд орж өнөөдрийн бидний мэдэх нэг өдөрт 24 цаг байдаг нь яг л энэ үеэс эхэлсэн юм. Бүтээлийн хүчийг харуулахын тулд махан биеийн орон зайг сүнслэг орон зайтай хамт угийн гэрлээрээ бүрхсэн. Сүнсний цаг хугацаа нь махан биеийн цагаас харьцуулашгүй илүү асар хурдан явдаг.

Махан биеийн цаг хугацаагаар хэдэн арван жил эсвэл хэдэн зуун жил зарцуулагдах ажлыг сүнслэг орон зайд зөвхөн ганцхан өдөрт хийж дуусгах боломжтой.

Мөн оргүй хоосноос угийн гэрлийн хүч чадлаар бодит зүйлийг бүтээх боломжтой байна. Угийн гэрэлтэй орон зайд сүнслэг хууль үйлчилж, Бурханы дотроо бодсон бүх зүйл нь биелдэг байна. Зарим зүйл нь оргүй хоосон зүйлээс бүтээгдэж, мөн ямар нэгэн бодисыг хий, шингэн, хагуу зүйл болгон өөрчилж чаддаг. Махан биеийн орон зай нь угийн гэрлээр сүнслэг орон зайтай хамт хучигдах үед бүх зүйл сүнслэг хуулийн дагуу явагддаг байна.

Жишээлбэл хорт хавдрын эс нь залбирал авсаны дараа тэр дороо алга болсон, мухар олгой дотроо хагарч хүндэрсэн ч мөн залбирал авсаны дараа өвчин хөндүүр нь тэр дороо арилах тохиолдол юм. Анагаах ухаанаар бол хагарсан мухар олгойн тэр хэсгийг зайлшгүй хагалгаа хийж цэвэрлэх шаардлагатай бол Бурханы эрх мэдэлт хүчийг авсан хүний залбирлаар өвчнөөсөө эдгэх хэмжээний итгэлтэй хүнд залбирал хийж өгсөнөөр хүнийг сүнслэг орон зайгаар хүрээлж нөлөөлдөг. Хугарсан яс эргэж нийлэх, үхсэн эд, эс амилах, сулдаж доройтсон эрхтэн хэвийн болох ч гэсэн угийн гэрлээр хучиж, сүнслэг орон зайг үүсгэж, түүн дотор дахин бүтээлийн үйлс бий болдог.

Хоёрдугаарт: Махан биеийн орон зайд угийн гэрлээр хучих нь дэг журам, зүй тогтлыг тогтоохын тулд юм.

“Дэлхий тэнхлэгээ нэг тойроход нэг өдөр харин нарыг нэг тойроход нэг жил болдог” гэсэн зүй тогтол байдаг. Зөвхөн нарны аймгийн гаригууд ингэж эргэлдэггүй хэдийгээр тэнгэрт үй олон одод байдаг ч тэр үй олон одод ч өөрийн гэсэн зүй тогтол хурдаар эргэлдэж байдаг. Тэд бүгдээрээ өөр өөрийн зарчмаар эмх замбраатай байдаг юм. Ус цельсийн 0 хэмд хөлдөж, 0-с дээш хэмд шингэн болж урсаж, харин 100 хэмд буцалж, уур болдог. Мөн улирал нь хавар, зун, намар, өвөл гэж ээлжилдэг.

Энэ мэт махан биеийн орон зайд шаардлагатай бүх дэг журам, зүй тогтлууд нь эхний өдөрт бий болсон юм. Бурхан тэнгэр газрыг бүтээх бүтээлийн эхний өдөр “Гэрэл бий бол!” гэж айлдан угийн гэрлээр бүрхсэнээр цаашид бүтээх бүтээлүүдийн хооронд дэг журам, зүй тогтлуудыг урьдаас товлосон тогтоосон юм (Иов 38:5).

Гуравдугаарт: Бурханы хүч ба бурханлаг шинж чанарыг бүх бүтээлүүдэд шингээхийн тулд юм.

Бурханы хүч бол үхсэнийг амилуулж, сайн өсгөж ургуулах чадал агуулагддаг. Жишээлбэл газарт үр суулгахад нахиалж, ургадаг. Байгалийн хуулиар бол үр соёолоход тохиромжтой газар, ус, нарны гэрэл, хэрэгтэй. Харин энэ газарт суулгах, ус, нарны гэрэл, амьтай бүхэн соёолж, ургаж байгаа нь бүгд Бурханы агуу хүч чадлаар хийгдэж байгаа юм.

Бүтээлийн анхны өдөр Бурханы энэ махан биеийн орон зайд дүүргэсэн угийн гэрэл нь дэлхий гэм нүглээр бохирлогдсоор бага багаар хураагдаж эцэст нь Ноагийн үерийн үед дийлэх нь хураагдсан билээ. Гэсэн ч угийн гэрэл өчүүхэн төдий үлдсэн ч бүх бүтээлүүдэд үйлчилж амьд орших бүхний гол хүч нь болж ажиллаж байна.

# “Орохдоо ч, гарахдаа ч ерөөгдөх” ерөөлийн эзэн болгож өгсөн Бурхан Аав

И Жей руг Тэргүүн пасторын залбирлаар хүнд өвчин маань эдгэрсэн

1991 онд дөнгөж 30 гаруйхан насандаа маш хүнд өвчинд (Тархи, нугасны үрэвсэл, архаг ядаргаа) баригдсан. Олон жилийн турш өвчнөө эмчлүүлж эдгээхийг хичээсэн ч нөхцөл байдал улам дордсоор байлаа. Ингээд 1996 онд Хуулийн байгуулагад ажилладаг байсан ажлаасаа гарч өвчинтэйгээ тэмцэж өдөр хоногийг арай ядан өнгөрөөж, бүр цөхөрч гүйцсэн билээ.

Нэг өдөр манай хаалганд хавчуулан үлдээсэн Манмин Мэдээ сонинноос хорт хавдрын сүүлчийн шатанд орсон нэгэн итгэгч эдгэрсэн тухай гэрчлэлийг уншаад маш их гайхсан. Тэгээд дараа нь Жонгро номын дэлгүүрт И Жей руг Тэргүүн Пасторын *Үхлийн Өмнөх Мөнх Амийг Амссан Нь* гэдэг номыг олж хараад худалдан авч шөнөжингөө нулимс асгаруулан уншсан билээ. Би ч бас өвчинөөсөө эдгэрч болох юм байна гэсэн итгэл найдвар надад төрж, 1997 оны бсарын 22нд Манмин Төв Сүмд гэр бүлийнхээ хамт ирж бүртгүүлсэн.

Ингээд би И Жей Руг пасторыг мэддэг болж, түүний зааж тайлбарласан сургаалиас өвчин зовлон гэм нүглээс ирдэг, бид бүхэн гэмших ёстой, тэгээд Библид бичигдсэн Бурханы Үгийн дагуу амьдарвал эдгэрэх болно гэдгийг ойлгож авсан. Энэ цагаас эхлэн Бурханы үгэнд болон хоньныхоо үгэнд дуулгавартай байхыг хичээж, И Жей Руг пастораас залбирал авсан билээ. Ингэж би хүнд өвчнөөс бүрэн эдгэрч, өдийг хүртэл 17 жилийн турш эрүүл саруул амьдарлаар амьдарч байна.

Бурханы үгээр амьдрахыг хичээхэд сүнслэг сэтгэлийг олж авсан нь

Миний өвчнийг эдгээж өгсөн Бурхандаа үнэхээр их баярлаж, эдгээгч Бурханы тухай гэр бүл, ах дүү, хамаатан садан, найз нөхөддөө ярьсан. Манай гэр бүл хамаатан саданы 70 гаруй хүн Манмин Сүмд бүртгэгдэж, жинхэнэ Христчин амьдралаар амьдарч амьдарч байна. Ямар их талархалтай вэ!

И Жей руг пастор Бурхан Аавын хүслийг сургаалиараа маш тодорхой заасан. Тэр бидэнд Христчин амьдралын хамгийн гол зорилго бол зөвхөн аврал аваад зогсохгүй цаашлаад Бурханы жинхэнэ хүүхэд болох юм гэж заасаар байсан. Тэгэхээр бид Бурханы хүслийг биелүүлсэн ариун хүмүүс болж, ариусах ёстой.

Бурханы жинхэнэ хүүхэд болохын тулд Тэр биднээс гэм нүгэл үйлдэхгүй, зүрх сэтгэлдээ хорон муугийн шинж ч үгүй байхыг хүсдэгийг би маш сайн ойлгож авсан. Тиймээс би Түүний хайр нигүүлсэлийнх нь хариуд ариусахыг чармайн зүтгэсэн бөгөөд бүх гэр бүл ах дүү хамаатан садныхаа хүмүүсийг авралын замруу удирдсан билээ. Бидэнд хий, бүү хий, мөрд, занш, гэж хэлсэн Бурханы үгийн дагуу бүх л чадлаараа дуулгавартай байхыг хичээсэн.

2011 оны 12 сарын 25нд И Жей руг пасторын итгэгчид рүүгээ хандсан чин сэтгэлийн залбирлаар хүчийг Бурханы хүсэлд нийцсэн зохистой сүнслэг зүрх сэтгэлийг бий болгож чадсан билээ. Тэнгэрийн орон миний сэтгэлд бууж ирсэн мэт амар тайван, баяр хөөрийг мэдэрч өдрөөс өдөрт аз жаргалаар дүүрэн байна.

Олон ажлыг хийж гүйцэтгэсэнээр Христчин амьдралын үлгэр жишээг харуулсан нь

Би хэсэг бүлэг, багуудын Удирдагчдын Холбоо, Санхүүгийн албаны гишүүдийг удирдагчдынх нь



Пак Хун ги ахлагч  
(1-4 хэсэг, Хуулийн хэсэг)

“Бурхан намайг хүнд өвчнөөс минь эдгээсэн тул Түүнийг эдгээгч гэдгийг баяр хөөртэйгээр номлодог.

...  
Үүгээр дамжуулан миний ахан дүүс 70 гаруй хүмүүс итгэгч болсон, би сүнслэг сэтгэлтэй болж итгэлтэйгээр ажиллаж, Бурхан намайг цаг үргэлж ерөөлийн замаар замчилсаар байгаа билээ.”



хувьд Христчин амьдралын жинхэнэ аз жаргалыг мэдрээсэй гэж хүссэн учраас ариусахын тулд сургалтын бүлгүүдийг зохион байгуулж эхэлсэн.

2012 оны 11 сараас 2013 оны 6 сарын хооронд найман сарын турш 40 гаруй хэсгийн эрэгтэй удирдагчтай бүтэн сайн өдөр бүр цуглан уулздаг байв. Бид өглөөний 8:30-9:30 хүртэл Библи уншиж судалдаг байлаа. Тун удалгүй 200 орчим хүн Санхүүгийн багаас болон бусад сүмээс бидний сургалтанд оролцохыг хүсч, 2013 оны 4сараас 11 сар хүртэл бүтэн сайн өдөр бүр оройны 7:20-8:20 хүртэл залбирч, Библи судалдаг болов. Тэдний ариусахыг хүссэн гал халуун сэтгэл, хичээл зүтгэлийн үр дүнд маш олон хүн итгэлийн хадан суурин дээр суурилж, мөн хэдэн хүн сүнс рүү орсон билээ.

Би ажилчдынхаа гэрээр очиж тэдэнтэй уулзаж байхдаа тэднийг хайрлах, сүнслэг хайр маань улам бүр нэмэгдэж байсан юм. Би Леви бүлгийн (Сүмийн үндсэн ажилчид) цуглаан, эрэгтэйчүүдийн эсийн бүлгийн үйлчлэл, болон бусад олон үйлчлэлд уригдаж, үг хуваалцаж, номлож байхад Бурхан надад ивээл ерөөлийг дүүргэж, гайхамшигтай хүч чадал өгч байсан учраас энэ олон ажлыг хичээнгүйлэн хийж чадсан юм.

2013 оны 7сарын 27нд Есүс Христийн Нэгдсэн ариун сүмийн Орлогч захиралаар сонгогдож, Бурханы хаанчлалын төлөө өөрийгөө зориулахаар болсон. Мөн 12сарын 29нд Сүмийн оны тайлагын хурлын үеэр жуух бичиг шагнагдсан. Бурханы хаанчлалын төлөө хичээн зүтгэж байгаа зүтгэлийг минь хараад Бурхан Аав маань сүнс болон махан биеийн агуу том ивээл ерөөлийг өгч, мөн ариусгаж сүнслэг итгэлээр өсгөж өгсөн юм.

Миний гэр бүлд, ажил, эрүүл мэндэд ерөөлөөр бялхсан нь

Бурхан миний биеийг одоо хүртэл эрүүл саруул байлгаж үргэлж хамгаалж байдаг учраас Манмин Төв Сүмд бүртгэгдсэнээс хойш би эмнэлэг рүү яваагүй. 2011 онд миний нүдний хараа 0.9/0.9 байсан харин 2013 онд 1.2/1.2 болж сайжирсан.

Хүнд өвчинөөс эдгэрсэнийхээ дараа хуучин ажилдаа эргэж орсон. Би чин сэтгэлээсээ сайн ажиллахыг хичээж байсан бөгөөд Аудитын албанд төрийн албан хаагч, байцаагчаар сонгогдон ажиллах болсон. 2010 оноос хойш Бурханы ивээлээр Lee & Ko гэдэг нэгэн томоохон хуулийн байгууллагад ажиллаж байна.

Lee & Ko-гийн The Mergers and Acquisitions (M&A) Групп нь Азийн хамгийн сайн үйл ажиллагаатай, Азидаа болоод Солонгос нэгдүгээрт бичигдсэн олонд танигдсан компани юм. Бурхан намайг өөрийгөө дайчилж гайхамшигтай үр жимс гаргахад ивээж өгсөн билээ.

Манай гэр бүл Шинэ Иерусалим руу орохоор Христчин амьдралаар маш хичээнгүй амьдарч байгаа. Миний эхнэр Чо Ми хёон сүмд үйлчлэгч 4-р хэсгийн удирдагчаар, мөн Эмэгтэйчүүдийн хэсгийн ахлагчаар ажилладаг. Миний хүү Пак Жон сеок ах дүүс Солонгосын Их Сургуулийг социологийн төгсөх ангийн оюутан, Бурханы хаанчлалын төлөө хичээнгүйлэн суралцаж байгаа. Миний охин Пак Сун ёонг 2013 оны 8 сард их сургуулиа төгсөөд нэгэн нэртэй компанид орж дэвшин ажиллаж байна. Одоо тэрээр илүү сайн мэргэшсэн ажилтан болохын төлөө хичээн ажиллаж байна.

Бид бүх алдар магтаал талархалыг Бурханд өргөж байна. Нэгэн цагт би хүнд өвчинд баригдсан ямар ч итгэл найдваргүй нэгэн байсан ч Бурхан надад сүнс, махан биеийн ерөөлийг бялхтал өгсөн билээ.

## Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

## залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

## Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:  
Г. Анхбаяр СМТ 976-91173712  
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manminministry@manmin.org  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин